



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/13

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих 2.18.1 жагсаалтад тусгагдсан Хоггүй Хөвсгөл-“50” Ковш худалдан авах /Их уул сум/ төсөл арга хэмжээний худалдан авах арга хэмжээг хууль, журмын дагуу зохион байгуулан гэрээ байгуулж хэрэгжилтийг ханган ажиллах захиалагчийн эрхийг Их-Уул сумын Засаг дарга (Б.Мянганбаяр)-д шилжүүлсүгэй.

2. Төсөл арга хэмжээг үр ашигтай, шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст сар бүр ирүүлж ажиллахыг Их-Уул сумын Засаг дарга (Б.Мянганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР